

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
“МОНГОЛ СУДЛАЛ”

Эрдэм шинжилгээний сэтгүүл

Боть XLVII (597)

DOI: 10.22353/ms20234713

ЦАХИМ САНД СУУРИЛАН ХҮҮХДИЙН ЗОХИОЛООС
ДУУРАЙХ ҮГИЙГ ТОДРУУЛАХ НЬ

Г.Нарантунгалаг
Т.Батбямба

Агуулгын товч: Хүүхдийн зохиолоор дамжуулан сурагчдад өгч байгаа мэдээлэл нь тэдний мэдлэг, чадвар, хандлага, сэтгэлгээг хөгжүүлж чадах, амьдрах ухааны арга, ёс суртахууны хүмүүжил төлөвшил олгож байгаа эсэх, хүүхдийн насны онцлогт тохирсон эсэх зэргийг харгалзан үзэх нь зүйтэй байдаг. Иймд бид зохиолч Д.Мягмарын “Балын амт” туужийн үгийн сангаар байгуулсан цахим хөмрөгт суурилж, уг туужийн нийт үгийн сан, давтамжийг AntConc программаар, үеийн хэлбэр, бүтцийг тооцоолж гаргав. Мөн давтамжийн тооцоололдоо тулгуурлаж, дуурайх үгийг илрүүлснээс гадна уран дүрслэлд ашигласан үгсийг тусгайлан авч үзэж, тус туужийн хэлний онцлогийг тодруулахыг зорив. Энэхүү туужийн хувьд давтагдсан тоогоор 9020, давтагдаагүй тоогоор 2665 үг бүрдсэн бөгөөд үгийн сан, үе, дуурайх үгийн тооцооллоос үзвэл тус зохиол нь 6-10 настай хүүхдийн үгийн санг баяжуулж, хэл найруулгыг сайжруулахад чиглэсэн зохиолуудын нэг гэж үзэж болно.

Энэ судалгаа нь уг туужийг хүүхдийн зохиолд хамруулж үзэж байгаа үндэслэлийг тооцооллоор дамжуулж гаргаж байгаагаараа ач холбогдолтой юм.

Түлхүүр үг: хүүхдийн зохиол, “Балын амт” тууж, Д.Мягмар, цахим сан, үгийн сан, давтамж, дуурайх үг, үе

Удиртгал

Судлаачид Д.Мягмар зохиолчийн хүүхдийн зохиолуудын талаар бичсэн дүгнэлтийг товч байдлаар танилцуулбал доорх байдалтай байна.

Д.Оюунбадрах: Д.Мягмарын зохиол бүтээлүүдийг дэлгэрэнгүй задлан шинжилж, “Балын амт” зохиол зөвхөн зөгийний ач тусыг өгүүлээд зогсоогүй тэр ашиг шимтэй амьтадтай ажиллах хүүхдийн дур хүслийг төрүүлэхүйц болсноороо онцлог юм (1987:25) гэж үнэлжээ. Д.Батжаргал “Хүүхдийн яруу найргийн уран чадварын зарим асуудал” номд “Зохиолч Д.Мягмарын “Харааны шилтэй морь” (Уб.,1976) номд “Хар хээрийн нүдэнд харааны шил хийсэн нь”, “Алагч үнээнд араа хийсэн нь”, “Үүл сорогч Үсүү аппарат” зэрэг богино найраглалуудад хүүхдийн сэтгэхүйг бодит үйл болгон бичсэн нь сонирхолтой. Морь таньж байгаа хэсгийг “хумбан туурайгаар нь шинжээд танина, алхаж явахад нь ажаад танина,

уяатай байхад нь үзээд танина, унгалдах дууг нь сонсоод танина, тормогор нүдийг нь тольдоод танина, толгой юуг нь илээд танина” гэх мэтээр уяач хүний гярхай сонин аргыг нээж бичсэний дээр хүүхдийн санаанууд хүсэл биш биелэл болдгийг үзүүлсэн нь шинэлэг юм (1976:196) гэж үнэлжээ. Ч.Билигсайхан “Арван хөрөг” номдоо: Д.Мягмар 1965 онд “Балын амт” гэдэг танин мэдэхүйн ач холбогдолтой тууж бичиж, хүүхэд багачуудад зөгийн талаар олон шинэ зүйлийг сэтгэлд санаанд нь хадагдан үлдэх адал явдлын хамт хоногшуулан үлдээжээ. Мөн “Харааны шилтэй морь”, “Анчин Дорж” зэрэг сонирхолтой номуудыг энд дурдах нь зүйтэй юм. Д.Мягмарын хянуур нямбай ухаан авьяасаар бүтээгдсэн эдгээр бүтээлүүд хүүхдийн оюун бодлыг тэлэхэд том хувь нэмэр оруулж байна гэжээ. Энэ мэтчилэн Ш.Цэнд-Аюуш (1986:216), Д.Өлзийбаяр (1987:51), Т.Баясгалан (2003:87) нарын судлаачид түүний уран бүтээлийн эрэл, нээлт, урлах эрдэм туужийн төрөлд илүү тод илрэлээ олсон байна хэмээн дүгнэжээ.

Л.Түдэв “Насанд хүрэгчдийн хэл хүүхдийн хэл хоёр эрс тэс зүйл байдаг юм шиг шаардлага тавих явдал бол нэг талаар инээдэмтэй, нөгөө талаар хөөрхийлөлтэй. Хүүхдийн зохиолын хэл нь насанд хүрэгчдийн ерийн цэвэр хэл байх бөгөөд хамгийн зөв, боловсон хялбар ойлгомжтой, хурц тод байх ёстой” гэж хүүхдийн зохиолын хэлний онцлогийг тодорхойлжээ. Харин ялангуяа бага насны хүүхдэд зориулсан зохиолд үгийн олон салаа утгаас хүүхдийн зайлшгүй мэдвэл зохих утгыг голчилдог бөгөөд нутгийн аялгууны үг, этгээд үг, бүдүүлэг үг хэллэгийг хэрэглэдэггүй, хэтэрхий чамирхсан гоё үгээр бичдэггүй онцлогтой билээ (1986:124).

Бага насны хүүхэд нь гэр бүл, цэцэрлэгийн хүрээнээс сурагчийн ширээнд шилжин бичиг үсэг сурч ном бие даан унших чадвартай болж улмаар төрөл бүрийн шинжлэх ухааны анхны мэдэгдэхүүнтэй танилцаж нийгмийн амьдралд оролцож эхлэх үе юм. Иймд энэ үед уран зохиол сонсогчоос уншигч болж зохиолын сэдэв адгуусны үлгэрийн хүрээнээс нийгмийн харилцааны сэдэв рүү аажмаар шилждэг. Тэгэхдээ хүний сэтгэл санаанд анализ хийсэн зохиол бус үйл явдлаар утга нь гарах зохиол илүү тохиромжтой (1986:118) байдаг бөгөөд хүүхдийн зохиолын хэл нь тухайн бүтээлийн утга санаа үйл явдлыг дүрслэх хэрэглүүр болохын зэрэгцээ хүүхдийн хэл яриаг хөгжүүлэхэд чухал нөлөөтэй учраас хэл найруулгад тавих шаардлага өндөр байдаг. Иймд хүүхдэд зориулсан зохиол нь тэдний хэл яриаг баяжуулах утга зохиолын найруулгын сайхан жишээ болохуйц хэлээр бичигдсэн байх шаардлагатай юм.

Үүнтэй холбогдуулан зохиолч Д.Мягмар хүүхдийн зохиолууд бичихээс гадна хүүхдийн зохиолын сэдэв агуулга, хэл найруулга, уран дүрслэл, яруу хэрэглүүр, танин мэдэхүйн ач холбогдол зэргийг Утга зохиол, урлаг сонины “Хүүхдийн утга зохиолын одоогийн зорилт” (1694 оны №4), “Хүн болох багаасаа” (1966 оны №11), “Хүүхдийн зохиол, уран чадвар” (1966 оны №2), мөн оны №52-т “Хүний бага насны утга зохиол” (1966 оны №52) тодруулсан нийтлэлүүд бичиж байжээ. Мөн энэ үеэс зохиолч Ш.Цэнд-Аюушийн “Хүүхдийн зохиолын онцлох хоёр төрөл хэлбэрийн тухайд” (1986), Д.Батжаргалын “Хүүхдийн яруу найргийн уран чадварын зарим асуудал” (2011), О.Сундуй “Хүүхдийн зохиолын хэл найруулгын онцлог” (2015), О.Шинэбаярын “Хүүхдийн хэл ба орчин” (2022), Ч.Бямбацэцэгийн “Уран зохиолд туссан хүүхдийн дүр” (2022) зэрэг илтгэл

өгүүлэл, ном бүтээлээс хүүхдийн зохиолын уран чадвар, хэлний онцлог, ур чадварын өсөлтийг хэрхэн үнэлж цэгнэснийг дэлгэрүүлэн үзэж болно. Хэдий тийм ч цахим санд суурилсан хүүхдийн зохиолын судалгаа цөөн байгаа нь энэ чиглэлийн судалгааг гүнзгийрүүлэн судлах хэрэгцээ шаардлага зайлшгүй байгааг харуулж байна.

Иймд юуны урьд Д.Мягмарын “Балын амт” туужийн үгийн сангаар материалын хөмрөг байгуулав. Байгуулсан хөмрөгөөсөө дуурайх үгийг ялган авч, тус зохиолын хэлний онцлогийг тодруулах, бусад тооцоололдоо тулгуурлаж гаргасан үр дүнг харьцуулан шинжилснээ танилцуулах зорилго дэвшүүлэв.

Уг судалгааны онцлог нь хүүхдийн зохиолоор жишээлж, тус зохиолын үгийн сан, үгийн үеийн хэлбэр, бүтцийг тодорхойлж, зохиолд ашигласан үгс нь хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохирсон эсэхийг тодорхойлох, дуурайх үгсийг гүнзгийрүүлэн авч үзэж, хэлний онцлогийг тооцоололд тулгуурлан гаргахад оршиж байна. Энэ нь цахим санд суурилсан хүүхдийн зохиолын судалгааг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр судлахын ач холбогдлыг тодруулахад чиглэж байна.

Судалгааны хэсэг

Судалгааны ажлын гол хэрэглэгдэхүүнээр Д.Мягмарын “Балын амт” туужийг сонгов. Уг тууж нь цахим хэлбэрээр олдоогүй тул текстийг хүний хүчээр компьютерт оруулж, Unicode -оор баримжаа код болгон хөрвүүлж бичвэр болгов. Бичвэрийн зөв бичих дүрмийн алдааг хянаж, эх материалтай тулгасны суурь дээр Notepad++ программыг ашиглаж, байгуулах гэж байгаа хөмрөгийн үндсэн тэмдэглэлийг бүрдүүлсэн юм. Үүний дараа “Балын амт” туужийн үгийн санг дараах хэд хэдэн талаас бүртгэн тооцоолсон нь доорх мэт байна. Үүнд:

1. Үгийн сангийн давтамж
2. Нийт үгийн үеийн тоо
3. Дуурайх үг гэх мэт болно.

“Балын амт” туужийн үгийн сангийн хэлний материалд илэрсэн давтамж

Үгийн давтамжийг Antconc программаар тооцоолов. Салангид бичигддэг *минь, чинь, тань, нь, руу, рүү, луу, лүү* зэрэг нөхцөлүүдэд тэмдэглэгээ хийв. Үгийн давтамжийн хувьд, хэлний материалд илэрсэн бүртгэлийн дүнг үндэслэвэл, тус хөмрөг нь 9020 үгтэйгээс давтагдаагүй тоогоор 2665 үг бүртгэгдсэн байна. Бидний байгуулсан материалын хөмрөгт хамгийн өндөр давтамжтай үгсийг хүснэгтээр үзүүлбэл доорх мэт байна.

Хүснэгт 1(Давтамжийн тооцоолол)

№	Үг	Давтамжийн тоо	Жишээ
1	гээж	183	Та нар чинь өөрсдөө ч үүгээр тэнээд л зөгийнүүд чинь ч бас... <i>гээж</i> үглэж гарав.
2	зөгий	165	Гэтэл бүх <i>зөгий</i> дорхноо дэрхийн нислээ.

3	юм	145	Пөөх чи тамхи татдаг юм уу гэж дуу алдлаа.
4	би	100	Би байшингийн хөл будаж суухдаа “Гайгүй дээ, та нарыг авирч чадахгүй болтол чинь өмхий хар тосоор будаад өгье” гэж амандаа бувтнан хэд давхарлан будлаа.
5	байгаа	90	Бас эргэн тойрон хүрээлсэн балар харанхуй ой, түүний дундуур хоржигнон урсах горхины шуугихыг чагнаж зогссоноо юм буулгаж байгаа хүмүүст туслахаар очив.
6	туяа	70	Гэтэл уулын дээгүүр нар хөөрч битүү ногоон ойн чөлөөгөөр алтан шар туяа мэлсхийн тусахыг хараад
7	ч	70	Та нар чинь өөрсдөө ч үүгээр тэнээд л зөгийнүүд чинь ч бас...гэж үглэж гарав
8	хоёр	67	Ойр хавийн цэцэг рүү дурандаж байтал урдуур хоёр ч махчин соно сүнгэнэн нисэж өнгөрлөө.
9	тэр	65	Би цэцэгт нугад дэрвэгнэн жиргэх болжмор болон төмөр замын далангийн шороон цогнойж буугаад хошуугаа цорволзуулан час час шивирэх үхэр оготнын дууг чагнатал тэр өчүүхэн амьтдын дуу азарган тахианы орилох дуунд замхрав.
10	бид	61	Туяа бид хоёр зөгийн хотоос баруун тийш, нэлээд явлаа.


Хүснэгтээс үзвэл хамгийн их давтамжтай үг нь 183 удаа илэрсэн бол аз, анх, аяга довжоо, дүгрэг, дүүлэх, жирвэлзтэл, золтой, зоргодос, лангуу зэрэг 1789 үг нь зөвхөн нэг удаа дурдагдсан байна. Энэ нь Д.Мягмарын үгийн давталтад ихээхэн анхаарч, зохиол бүтээлээ туурвидаг байсны жишээ юм.

“Балын амт” туужийн үгийн сангийн хэлний материалд илэрсэн үеийн бүртгэл

“Балын амт” тууж дахь үгсийн үеийн бүртгэлийг гаргахын тулд үгийн уртыг тооцоолбол тус хөмрөгт хамгийн олон үсгээс бүтсэн үг нь “тэмдэглэлийнхээ” (15 үсэгтэй), “суурилуулчихвал” (15 үсэгтэй), “бариулчихсанаас” (15 үсэгтэй), “үргэлжлүүлэхээр” (15 үсэгтэй) дөрвөн үг бүртгэгдсэн бол хамгийн цөөн буюу нэг үсгээс бүтсэн үг нь “л” (1 үсэгтэй), “ч” (1 үсэгтэй) гэсэн дагах баймж утгатай үг байна.

Үеийн бүтцийн тооцооллын хувьд, хэлний материалд илэрсэн бүртгэлийн дүнг үндэслэвэл, тус хөмрөгт V (уу), VC (ид), VCC (авч), CV (дуу), CVC (бүх), CVCC (нэрс), гэсэн үеийн 6 хэлбэр илэрсэн бөгөөд хамгийн өндөр давтамжтай “эс-вэл”, “эх-лэх” гэх мэт 2 үетэй 1518 үг, хамгийн бага давтамжтай “сар-ва-га-гуу-лан”, “и-нээм-сэг-лэ-хэд” гэх мэт 5 үетэй 13 үг тохиолдов. Мөн тус хөмрөгт “дээрх”, “галт” гэх мэт 1 үетэй 334 үг, “шуур-га-тай” (3 үетэй), “шил-жүүл-дэг” (3 үетэй) гэх мэт үг 604 удаа, “бай-шин-гийн-хаа”, “гу-дамж-луу-лан” гэх мэт 4 үетэй 196 үг тохиолдов.

Хүснэгт 2. (“Балын амт” туужийн нийт үгийн үеийн тоо)



“Балын амт” туужийн үгийн сангийн хэлний материалд илэрсэн дуурайх үгийн бүртгэл.

Дуурайх үг нь өгүүлбэрийн бүтэц дэх гол ба туслах үгийн аль алиных нь дундын шинжтэй, үгийн сангийн бие даасан утгагүй, давтаж хоршиж, болц байдал заасан байц гишүүн болдог (2021:194). Дуурайх үгийн тооцооллын хувьд, хэлний материалд илэрсэн бүртгэлийн дүнг үндэслэвэл, тус хөмрөгт “час час”, “час пас”, “тас тас” гэсэн үгс илэрчээ. Холбогдох жишээг үзүүлбэл доорх мэт байна.

– Би цэцэгт нугад дэрвэгэнэн жиргэх болжмор болон төмөр замын далангийн шороон цогнойж буугаад хошуугаа цорволзуулан **час час** шившрэх үхэр оготнын дууг чагнатал тэр өчүүхэн амьтдын дуу азарган тахианы орилох дуунд замхрав. Гэтэл азарган тахианы дуу ойн дунд донгодох хөхөөн дууны дэргэд тун ч эв хавгүй мэт санагдахад би өөрийн эрхгүй инээмсэглэнэ.

– Би нислэгт гарч байгаа зөгийг ажиглан нар хөөрч шумуул татрахыг хүлээж хүзүү нүүрэн дээгүүр суусан шумуулыг **час пас** хийтэл алгадаж “муу сайн махчин шумуул, та нарыг би нэг сайн чадаад өгье. Утаанаас айхгүй байхыг чинь үзэх юм сан.”

– Нөгөө баавгайн зөгийн үүрний балыг нохой шиг хээвнэг долоож урдуураа дүнгэнэн эргэлдэж байгаа зөгийг үнхэх гэсэн мэт амаа ангалзуулан шүдээ **тас тас** хийтэл хавирч байв.

Хүний сонсох эрхтэнд мэдрэгдэж байгаа дуурайх үгсийг илэрхийлэх боломж хязгаарлагдмал учир дагавар залгаж болон давтаж хоршиж бүтсэн дуурайх үгс цөөн илэрсэн гэж үзэж байна.

Монгол хэлний дуурайх язгуурт +на⁴ дагаврыг эгшгийг нь зохицуулан залгаж, уул язгуураар илрэх байдлыг дахин давтан үйлдэх утгатай үйл үг үүсдэг бөгөөд дээрх утга бүхий *сэржигнэн, сүнгэнэн, дүнгэнэн, хүнгэнэн, шоржигнон, хоржигнон* гэсэн 6 үйл үг тус хэлний материалын санд бүртгэгджээ. Холбогдох жишээг үзүүлбэл доорх мэт байна.

– Зогсоолын зүгээс үе үе **сэржигнэн** үлээх сэвэлзүүр салхинд тосны эхүүн хурц үнэр хааяа хүчтэй үнэртэнэ.

– Ойр хавийн цэцэг рүү дурандаж байтал урдуур хоёр ч махчин соно **сүнгэнэн** нисэж өнгөрлөө.

– Ажиглалтын шилэн байшингаас гарсан хэдэн мянган зөгий нар гарах зүүн өмнө **хүнгэнэн** ниссээр төдий л хол биш бяцхан нуурын зүүн эрэг дээрх шигүү ургасан ягаан цэцгэн дээр бууж бал цуглуулах ажилдаа орлоо.

– Ажилчин зөгий ч саяын дуу чимээнээс цочиж **дүнгэнэн** нисээд хажуугийн цэцгэн дээр буулаа.

– Ах маань өндөр суурин дээр байрлуулсан модон торхны ёроолын гоожуурыг нээж нарийнхан модон ховоо уруу ус **шоржигнуулан** урсгаж байв.

– Бас эргэн тойрон хүрээлсэн балар харанхуй ой, түүний дундуур **хоржигнон** урсах горхины шуугихыг чагнаж зогссоноо юм буулгаж байгаа хүмүүст туслахаар очив.

Дээрхээс үзвэл хүүхдийн зохиолын хэл нь энгийн ойлгомжтой байхаас гадна үгийн нөөцийг нэмэгдүүлж, өргөжүүлэн баяжуулахад чиглэсэн байдаг нь ажиглагдаж байна.

Дүгнэлт

Дээрх судалгаанаас үзвэл Д.Мягмарын “Балын амт” туужийн үгийн сангийн 19,83 хувийг нэг удаа илэрсэн үгс эзэлж байгаа нь тус тууж хүүхдийн нас сэтгэхүй, танин мэдэхүйн онцлогт тохирсон хэл найруулгатай болохыг харуулж байна.

Хүний сонсох эрхтэнд мэдрэгдэж байгаа дуурайх үгсийг илэрхийлэх боломж хязгаарлагдмал учир уг туужид давтаж хоршиж бүтсэн “час час”, “час пас”, “тас тас” хэмээх дуурайх үгс илэрсэн байна.

Зохиолч “Балын амт” тууждаа дуурайх үгсийг сэржигнэн, сүнгэнэн, дүнгэнэн, хүнгэнэн, шоржигнуулан, хоржигнуулан зэрэг үйл үгээр төлөөлүүлж аливаа юмс үзэгдлийн дүр зургийг уншсан хүүхдийн санаа сэтгэлд буухуйц тодорхой, ургуулан бодоход сонсогдохуйц сонирхолтойгоор бичсэн нь зохиолчийн уран чадварыг илтгэж байна. Дуурайх үгсийн утгыг шууд ойлгоход бэрхтэй учир нас сэтгэхүйн онцлогт тохирохгүй хэмээн шууд дүгнэх нь өрөөсгөл юм. Харин тэдгээр үгсийг толь бичгийн тайлбараар бус уншигчдын онцлогийг харгалзан үзэж энгийн ойлгомжтой үгээр бичих нь зүйтэй.

Бидний энэхүү судалгаа бол сурах бичигт агуулагдаж байгаа зохиолын үгийн урт, үеийн хэмжээ, дуурайх үгийн хэрэглээг тооцоо бүртгэлд суурилж судлах туршилт болно. Энэ нь цаашид монгол үгсийн сангийн утга судлал, сурах бичиг судлал, эх зохиол судлал зэрэгт суурь эх хэрэглэгдэхүүн болох боломжтой юм.

Ном зүй

- Оюунбадрах Д. (1987) *Монголын хүүхдийн уран зохиол*, Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар
- Батжаргал Д. (2011) *Хүүхдийн яруу найргийн уран чадварын зарим асуудал*, Улаанбаатар: Чөлөөт монгол хэвлэлийн газар.
- Цэнд-Аюуш Ш. (1986) *Хүүхдийн зохиолын онцлох хоёр төрөл хэлбэрийн тухайд*, Утга зохиолын шүүмжлэл 84, Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.
- Өлзийбаяр Д. (1987) *Хүүхэд, зохиолч, уран бүтээл*, Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.
- Баясгалан Т. (2003) *XX зууны монгол зохиолчид Намтар, уран бүтээлийн товчоон: Боть 89: Төрийн шагналт зохиолч Дэмбээгийн Мягмар*, Улаанбаатар: Бемби сан.
- Утга зохиолын шүүмжлэл-84*. 1986. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.
- Өнөрбаян. Ц., Жумдаан., Л, Саруул-Эрдэнэ. М., Ганбаатар. Ж, (2021) *Монгол хэл судлал -Үгийн сан судлал, IX боть*, Улаанбаатар

Abstract

That is vital to take into account whether the information provided to students through children's literature can develop their knowledge, abilities, attitudes, and thinking, whether it provides life skills, moral education, and whether it is appropriate for the age of the child. Therefore, based on the electronic database of the author D. Myagmar's novella "Taste of Honey", we calculated the total vocabulary and frequency of the novella, as well as the generation form and structure, using the AntConc program. Also, based on the frequency calculation, in addition to identifying the imitation words, the words used in the illustrations were specially considered, and the language characteristics of the novel were clarified. This novella consists of 9,020 repeated words and 2,665 non-repeated words. According to the calculation of vocabulary, syllables, and imitation words, the novel can be considered one of the novels aimed at enriching the vocabulary of 6-10-year-old children and improving language composition. This study is significant because it provides the rationale for including the novel in children's literature through computations.

Keywords: Children's literature, "Taste of Honey", D. Myagmar, electronic corpus, vocabulary, frequency, emulate